



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн есдүгээр хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
05 дугаар сарын 30-ны
өдрийн 9/11 дугаар тушаалын
хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Сүхбаатар аймаг, "Оточ-Болор" эмнэлэг	113/2025	3 жил	2025.05.01	2028.05.01
2.	Сүхбаатар аймаг, Аймгийн нэгдсэн эмнэлэг	114/2025	3 жил	2025.05.01	2028.05.01
3.	Сүхбаатар аймаг, Халзан сумын эрүүл мэндийн төв	115/2025	2 жил	2025.05.01	2027.05.01
4.	Сүхбаатар аймаг, Онгон сумын эрүүл мэндийн төв	116/2025	3 жил	2025.05.01	2028.05.01
5.	Сүхбаатар аймаг, Түмэнцогт сумын эрүүл мэндийн төв	117/2025	3 жил	2025.05.01	2028.05.01
6.	Булган аймаг, Сэлэнгэ сумын эрүүл мэндийн төв	118/2025	2 жил	2025.05.08	2027.05.08
7.	Ховд аймаг, Дуут сумын эрүүл мэндийн төв	119/2025	2 жил	2025.05.06	2027.05.06
8.	Баян-Өлгий аймаг, Цагаан нуур тосгоны эрүүл мэндийн төв	120/2025	2 жил	2025.05.08	2027.05.08